



Сибирийн талаархи Хятадын бодлого

Хүн ам ихтэй хүчирхэг улс газарзүн байршлын хувьд хүн ам цөөтэй улс оронтой зэрэгцэн оршиж буй нөхцөлд хүчирхэг гүрний зүгээс эдийн засаг, хүн ам зүй, цэргийн түрэмгий бодлогоор үргэлж заналхийлж байдаг. ОХУ-ын эдийн засгийн сул хөгжилтэй хүн ам бага суурьшсан бүс нутгуудын нэг нь сибирь юм. Орос хүчирхэг байдлаа алдсанаас эмзэг газар болоод байгаа эдийн засаг, хүн ам суурьшлын хоосон орон зай Сибирь, эрчимтэй хүчирхэгжиж буй хөрш хятадын анхаарлыг хүчтэй татаж байна. ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин 2000 оны 7 сард Сибирьт ирэхдээ алс дорнодыг хөгжүүлэх шийдвэртэй алхмуудыг ойрын үед хийхгүй бол хэдэн арван жилийн дараа эндхийн оршин суугчид үндсэндээ Япон, хятад, солонгос хэлээр ярих болох нь гэж мэдэгдсэн байна. Оростой хил залгадаг хятадын зүүн хойд 3 мужид 150 сая хятадууд амьдардаг байхад ОХУ-ын энэ хэсгийн 4 мужид 7 сая оросууд амьдарч байгаа нь хүн амын суурьшлыг хувьд анхаарал татаж байна. ОХУ-ын нутаг дэвсгэрт хичнээн хятад амьдарч буй тодорхойгүй байна.

Зарим эх сурвалжаас авсан мэдээгээр ОХУ-д ил ба нууцаар амьдарч буй хятадуудын тоо 1 саяас 2 саяын хооронд хэлбэлздэг аж. ОХУ-ын цагаачлал ба үндэсний бодлогын яамны мэдээнд ОХУ-д хууль бусаар 700,000-1,500,000 гадаадын иргэн амьдарч байгаагаас дөнгөж 30 гаруй мянган гадаадын иргэн бүртгүүлсэн бөгөөд албан ёсны эрх авсан гэжээ. ОХУ-д 56 орны хууль бус цагаачид амьдардгийн ихэнх нь хятад, вьетнам, афганчууд юм.

Албан ёсны мэдээгээр Сибирьт түр хугацаагаар 300,000 хятад амьдардаг гэх боловч жинхэнэ тоог нь гаргах бололцоогүй байна.

Сибирьт хууль бусаар амьдарч буй хятадын иргэд оросын иргэдтэй жинхэнэ ба хуурамчаар гэрлэх замаар оросын иргэн болж иргэний паспорт олж аван өөрсдийн байдлыг хууль ёсны болгохын төлөө маш их хүчин зүтгэл гаргадаг бөгөөд ийм боломжийг олсон хэсэг нь оросын өргөн уудам нутгаар хууль бусаар сэлгүүцэн байна.

Оросод ирж буй хятад иргэдийн ихэнх нь ажлын чадвартай, залуу эрчүүд бөгөөд ямар ч ажлаас шангардаггүй оросуудаас илүү чадварлаг, өртөг хямдтай хийдэг нь үйлдвэрийн ихэнх салбарт оросын олон иргэн жинхэнэ өрсөлдөн ялагч болж чадахгүй нь тодорхой.

Дэлхийн бүх томоохон хотуудын тогооч, үйлчлэх бүрэлдэхүүн хортой хүнд нөхцөлд ажиллагсад ачаа ачигч хог цэвэрлэгчдийн ажлыг хятадын цагаачид хийдэг нь бодит үнэн билээ.

Иймээс аугаа их хөрш гүрний зүгээс хийж буй хзүн амын ил түрэлтийн эсрэг хэрхэн тэмцэх талаар бодох төдийгүй Сибирь алс дорнодод суурьшсан олонтооны хятад иргэдийн хувьд баримтлах төрийн бодлогыг олон талаас нь нятлан үзэж боловсруулах шаардлагатай болжээ.

Оросын өнөөгийн сул байдал хятадын хүчирхэгжилтийн харьцаа ихсэх тусам хямрал үүсэх магадлал улам өндөр болох юм. Оросын улс төрчид энэхүү нөхцөл байдлыг ойлгон өнөөгийн энэ хандлагыг үргэлжлүүлээд байх юм бол хятад улам хүчирхэгжиж орос улам доройтож харилцааны төвөгтэй байдал бий болж мэдэх юм. Хүчирхэгийн туйлд хүрсэн хятад хэрхэн хандахыг хэлэхэд бэрхтэй. Хөршөөсөө илү хүчирхжсэн хятад бусдыг эзлэн түрэмгийлэгчид хараатууд гэж үздэгийг бид түүхээс мэдэх билээ. Ирээдүйд хятад ингэх байх гэж батлахыг оролдохгүй ч ийм эргэлтээс сэргийлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хятадын зүгээс хил ормын нутаг дэвсгэрт санаархах цэргийн аюул нь бодитой болж байна. хятад нь 2,6 сая цэрэгтэй. Дэлхийд хүчирхэг армитай. 1997-2000 онуудад армия 500,000 хүнээр цомотгосон цэргийн тоогоор бусад орны армиудаас үлэмж давуудаа бээжин санаа амарахаа байж чанарын давуу байдлыг хүсэх болов.

Хятад зэвсэгт хүчнээ Оросын шинэ хүчирхэг зэвсэгээр богино хугацаанд зэвсэглэж, оросын цэргийн аж үйлдвэрт идэвхитэй туслаж байна. Хятад нь олон зориулалттай сөнөөг онгоц СУ зенит пуужингийн цогцолбор, орчин үеийн хөлөг онгоц, шумбагч завинуудыг худалдан авагч гол түнш боллоо.

ХИЛ СУДЛАЛ

Хятадын пуужинд цөмийн хүч асар хурдацтайгаар хөгжиж байна. Одоо хятадын ардын чөлөөлөх армийг хэн ч даавуу гуталтай арми гэж хэлж чадахгүй. Хятад улс ХАЧА-г шинэчлэхэд хөрөнгө мөнгө харамгүй зориулж байна. Одоогийн цэргийн зардал нь 141 тэрбум юань буюу 17 тэрбум доллар юм. Цэргийн шинжээчид хятадын цэргийн бодит зардал нь албан ёсны тооноосоо 3-5 дахин их гэж үздэг.

Хятадын эрх баригчид нь зэвсэг техник худалдан авах болон шинжлэх ухаан, туршилтын ажилд зориулж буй зардлынха талаар дуу гаргахгүй байх, мөн ХАЧА-ийн худалдааны орлогод тооцогддоггүй хятадын цэргийнхэн жилийн 18 тэрбум долларын орлоготой эм, холбооны хэрэгслийн болон бусад салбарын 15 мянган үйлдвэр аж ахуйн газрыг эзэмшдэг. ХАЧА нь бүх томоохон хотуудын үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэг бөгөөд тэдний мэдэлд энгийнээс 5 одтой хүртэлх 1500 зочид буудал байдаг. Хятадын баглан хамгаалах зардал байнга өссөөр байна.

ОХУ-аас Хятадын зэвсэгт хүчинд нийлүүлсэн зэвсэг техник, технологийн байдал

Зэвсэг технологийн төрөл	Тоо	Гэрээ байгуулсан он	Нийлүүлэх хугацаа
Сөнөөгч онгоц СУ- 27	48	1991	1992-1995
Сөнөөгч онгоц СУ- 30МК	50	1999	2000-2002
Нисдэг тэрэг МИ-17	35	1990	1997
Нисдэг тэрэг КА-28	12	1998	2000
Пуужингийн цогцолбор газар агаар –С300	30	1990	1992-1998
Шумбагч завь Кило	4	1993	1994-1997
Гэнгисийн крейсер Современный	2	1997	2000
Танк Т80	200	1993	1996
Сөнөөгч онгоц СУ-27СК			
Үйлдвэрлэх лиценц	200	1996	1998-2000
Сөнөөгч онгоц СУ-30МКК			
үйлдвэрлэгдсэн лиценц	200	2000	
Пуужин эсэргүүцэгч АВАКС цогцолбор	1	2000	

Бээжин цөмийн зэвсэгийн хүчин чадал, нөөцөө улам нэмэгдүлсээр байгаа бөгөөд ойрын 10 жилд цөмийн пуужингийн байлдааны хошууны тоо нь 600-900 нэгж болтлоо өсөх хандлагатай.

ОХУ-ын зэвсэглэлийн салбарт өөрийн байр сууриа ихээр алдаж буй энэ цаг үед эхний ээлжинд Оросын Сибирь, Монголд улсыг чиглэн улам хүчирхэгжиж буй ХАЧА-ийн эсрэг сөрж зогсох алсын хараатай цэргийн бодлого боловсруулахыг цаг үе шаардаж байна. Хятадын зэвсэгт хүчний эсрэг өмнөд хөршөөсөө өөрийгөө батлан хамгаалах үүргийг бараг биелүүлж чадахгүй шахам Монголын зэвсэгт хүчин оросын цэргийн харьцангуй бага хүч төвлөрсөн байгаа нь түгшүр трүүлэхээс аргагүй юм. Ингэж хятадын цэргийн хүчин чадлын өсөлт нь орын хөршүүд ялангуяа оросуудын сэтгэлийг түгшээж байна.

Аливаа улс орны зэвсэгт хүчин болзошгүй дайснаас хамгаалахад зориулагдсан байдаг. Зэвсэг техникийн асар их бий болсон нь хоосон буу хорин жилд нэг удаа дуугардаг гэдэгчлэн хэзээ ч юм нэг уда дуугарч зэвсэгт мөргөлдөөнд хүрч болзошгүй бөгөөд энэ нь ойрын хөршүүд аюултай юм.

Сибир болон Монголын чиглэлд алсын бодлогоо хэрэгжүүлэхийн тулд хятадын бээжингийн цэргийн тойрог оросын холбооны улсын сибирын цэргийн тойргийн эсрэг зогсож байдаг.

Хүч хэрэгслэлийн харьцаа

Сибирийн цэргийн тойрог		Бээжингийн цэргийн тойрог
Бие бүрэлдэхүүн	150,000	410,000
Арми корпусын тоо	2	5
Мотобуудлагын дивиз /бригад/	2	13
Ганкийн дивиз	3	3
Артилерийн дивиз	1	1
Бригад	10	
Ганк	4468	3426
Хуягт тээвэрлэгч	6000	3280
Их буу	4300	3510
Онгоц	515	802
Нисдэг тэрэг	35	150-200

(батлан хамгаалахын цагаан ном УБ 2001. 22 тал)

ХИЛ СУДЛАЛ

Хүчирхэг зэвсэгт хүчинтэй хятад нь оросын армийн хүч ихээхэн суларсан энэ нөхцөлд оросын алс дорнод сибирийн хилд бодит аюулыг учруулах хүч хэвээр байна. Тухайн бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд Америк багагүй үүрэг гүйцэтгэж байдаг.

Сүүлийн үед Америкийн ашиг сонирхлын бүс ирээдүйн тэргүүний технологийн их хөдөлгөгч хүч болох Ази НомхонДалайн бүстэй давхцаж байгаа нь бүгдэд илэрхий бөгөөд Америкийн гадаад бодлогын бүхи йл бичиг баримтанд Хятад мөн дурьдагдах болсон. Америкчууд улс төр цэрэг техникийн хувьд дэлхийд ноёлох байр суурта үзүүлэх хадгалахад болон улс төрийн гадаад дотоод асуудлаа шийдвэрлэхэд (Хятадын аюул) гэдэг үзлийг дэвэргэхийг чухалчилж байна.

Дэлхий дахинд учруулах Хятадын аюул гэж ярих нь юуны түррүнд уналтанд орсон хямралд буй Америкийн цэрэг аж үйлдвэрийнхэнд ашигтай байгаа юм. 80-аад оны дунд үеэс тэнд ажилласдын тоо 30 хувиар, худлдааны эргэлт 50 хувиар буурчээ. Хятад улс нь АНУ-ын зүгээс ялангуяа үндэсний ба бүс нутгийн нуужингийн довтолгооноос хамгаалх систем байгуулахтай холлбогдсон асуудлаар шахалт үзүүлэх болсныг мэдэрч хятадын улс төрчид Вашингтоны бодлогод болон Хятад Америкийн харилцаанд шүүмжлэлтэй хандах болсон байна.

Орос Хятад хоёр нийлээд ч Америкийн баримталж буй тэдний эсрэг чиглэсэн алсын бодлогод ямар нэг өөрчлөлт оруулах бололцоо бага байна. Хүч чадал нь суларсан Орос Хятадын түншлэл нь тэдгээрийн олон улсын харилцааны томоохон ололт юм. Энэ нь Орос Америктай сөрөн зогсоход тайван ар талтай байх нөхцөлийг хангахад ач холбогдолтой байна.

Өрнө ба дорнын харьцааг тэнцвэржүүлэх, Хятадтай нягт хамтын ажиллагаа нь Оросын бодлогын хамгийн ашигтай хувилбар юм. Энэ нь Оросыг мухардлаас гаргахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд Орос орны ирээдүйн болон дотоод асуудлыг юуны өмнө эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхээс шалтгаална. Хятад нь хөрш Орос улсын нутаг дэвсгэрийг аажим аажмаар эзэмшихэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байна.

Энэ зорилгоор хил орчмын нутаг дэвсгэрт Хятадын хөрөнгө оруулалтыг чиглүүлэн түүхий эдийг зөөж боловсруулах зорилготой хамтарсан үйлдвэрүүдийг байгуулж Хятад иргэдийг өрнөдөд цагачлахыг сайшаан дэмжиж байна. Оросын экспорт юуны өмнө Сибирынх Хятадын зах зээлийн эрэлт хэрэгцээ нийлүүлэлтээс ихээхэн хамааралтай.

ОХУ-ын тал түүхий эд, хаягдал төмөр, байгалийн эрдэс, мод гаргаж Хятадаас өргөн хэрэглээний бараа, нэхмэл бараа болон голдуу өөрсдөөс нь зөөгдсөн түүхий эдээр хийгдсэн бараа материал орж ирдэг. Үүний зэрэгцээ Хятадын худалдаачид Оросоос худалдан авч буй түүхий эд, материалын гарал үүсэл, эрүүгийн шинжтэйг сонирхдоггүй. Тухайлбал дараах жишээг дурьдаж болох бөгөөд Сибирь алс дорнодын засаг захиргааны удирдлага эрчим хүч үйлдвэрлэгчид Хятадуудын худалдан авч буй өнгөт төмөрлөг, цахилгаан дамжуулах утас нь бүгд эрчим хүч үйлдвэрлэгчдийнх бөгөөд энэ нь бидний сэтгэлийг ихээр зовоож байдаг гэжээ. Энэ нь цахилгаан тасрах төдийгүй улс орны үндэсний эрх ашигт ихээхэн хохирол учруулж буй явдал юм.

Энэ нөхцөл байдалд Оросын хувьд Орос Хятадын нутаг дэвсгэрийн ирээдүйтэй харилцан ашигтай харилцааг бий болгох тодорхой чиг шугам боловсруулахыг :Хятадын харъяат олон иргэд нууцаар амьдарч, ямар ч ажлыг хийхэд бэлэн байгаа байдал хил орчмийн томоохон хот болгонд бий болсон, тэдгээрийг өргөн хэрэглээний бараагаар тасралтгүй хангадаг Хятадын захууд, мөн их хөршийн зүгээс үзүүлэх байнгын цэргийн аюул зэрэг нь бодит байдал болж байна.

Монгол улсын ХААИС-ийн Буриадын В.Р.Филипповын нэрэмжит ХАА Академи. Монгол улсын философи социологи эрх зүйн хүрээлэнгээс 2001 онд зохион байгуулсан Народы Центральной Азии 21 века Олон улсын эрдэм шинжилгээний хамтарсан экспедицийн тайлангийн хуралд Д.В.Ганжуровын тавьсан илтгэлийг товчлон орчуулсан.

*Докторант, хурандаа Б.Бат-Эрдэнэ
Докторант дэд хурандаа Ц.Ганболд*